

СОЦИОЛОГИ БА СЭТГҮҮЛ ЗҮЙ: ХАРИЛЦАН ХАМААРАЛ, НИЙТЛЭГ БА
ЯЛГААТАЙ ТАЛУУД

М.Зулькафиль*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Dr.Sc.)

Түлхүүр үгс: масс медиагийн социологи, олон нийтийн санаа бодол, хэвлэл мэдээллийн онол, сэтгүүлчийн ур чадвар, мэдээллийн хэрэгцээ, системийн хямрал.

Оршил. Манай орны сэтгүүл зүйн судлалд хамгийн бага судлагдсан асуудлын нэг бол сэтгүүл зүйн социологи юм. Энэ өгүүллийг бичигчийн “Сэтгүүл зүйн социологи: онол, практик, арга зүй” (2020) нэг сэдэвт бүтээлийг эс тооцвол бусад судалгааны шинжтэй бүтээл харахан гараагүй гэж хэлж болно. Өнөөдөр сэтгүүл зүйн социологи дэлхийн сэтгүүл зүйн судлалд бие даасан томоохон салбар болон хөгжиж, аливаа орны ОНМХ-ийн хөгжлийн чиг хандлага, хэрэглэгчдийн мэдээллийн эрэлт хэрэгцээг сэтгүүл зүйн социологи-гүйгээр төсөөлөх, тодорхойлох боломжгүй болжээ. Тиймээс энэ сэдвийг тусгайлан судлах шаардлага хурцаар тавигдаж байна. Нөгөө талаар ОНМХ-ийн ямар ч асуудлыг сэтгүүл зүйн социологийн тухай мэдлэггүйгээр ул суурьтай судалж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт хийж, үнэлэлт өгөх боломж ч хомс байна. Энэ бүхнийг иш үндэс болгон зохиогч энэхүү өгүүлэлд

социологи ба сэтгүүл зүйн харилцан хамаарал, тэдний хоорондох нийтлэг болон ялгаатай талуудыг, масс медиагийн судлал дахь сэтгүүл зүйн социологийн ач холбогдол, гүйцэтгэх үүргийг ОНМХ-ийн практик үйл ажиллагааны жишээн дээр гаргаж өгөхийг зорилго болгосон. Ингэхдээ зохиогч харьцуулан судлах, бүтэц-үүргийн, системийн шинжилгээ, контент анализын аргыг голлон хэрэглэхийг хичээсэн юм.

Сэтгүүл зүйн социологи ба сэтгүүл зүйн харилцан хамаарал. Нийгмийн салбар, үзэгдэл бүр өөрийн социологитой байдаг. ОНМХ-үүдийн төлөв байдал, хөгжлийн үйл явц, үйл ажиллагааных нь нийгмийн үр дагаврыг нийгмийн хүчин зүйлсийн нөлөөлөлд нь авч судлах социологийн салбар ухааныг сэтгүүл зүйн социологи, заримдаа олон нийтийн мэдээллийн социологи (Sociology of Mass Media) гэж нэрлэдэг. Сэтгүүл зүйн социологи бол хэвлэл мэдээллийн тухай, бүр тодруулж хэлбэл, сэтгүүл зүйн нийгмийн (социал) онолын тухай мэдлэгийн цогц юм.

Сэтгүүл зүйн социологи бол нэг талаар нийгмийн (социал) танин мэдэхүйн өвөрмөц салбар, нөгөө талаар сэтгүүл зүйг чиглэсэн зорилготой

судлах явдал юм. Сэтгүүл зүйн социологи ОНМХ-ийн системийн доторх хөдөлгөгч хүчнүүд, үйл явц, зүй тогтлуудыг гүнзгийрүүлэн судалдаг шинжлэх ухааны танин мэдэхүйн бие даасан, өргөн хүрээтэй салбар болох сэтгүүл зүйн онолын нөлөөн дор бүрэлдэн тогтдог бөгөөд шүүмжлэх, чиг баримжаа тогтоох, таамаглал дэвшүүлэх үүргийг голлон гүйцэтгэдэг. Түүний гол зорилго нь нийгмийн бүтэц эсвэл олон нийтийн санаа бодолд гарсан ямар өөрчлөлт сэтгүүлчийн сэтгэхүй болон зан үйлийн хэлбэр, төсөөлөл, чиглэл, зорилгод яаж нөлөөлөх вэ гэдгийг ойлгуулах, тайлбарлахад оршино.

Сэтгүүл зүйн социологи бол дээд зэргийн “практик” шинжлэх ухаан бөгөөд ямар ч нөхцөлд ирээдүйн мэргэжилтний бэлтгэлийн чухал хүчин зүйл мөн. Социологи бол зөвхөн онолын төдийгүй, ямар ч эргэлзээгүй хавсарга ухааны хувьд чухал ач холбогдолтой юм. Энэ бол харьцангуй тусгай үзэгдэл болох сэтгүүл зүйн социологитой ч хамаатай. Учир нь сэтгүүл зүйн социологи бол нэг талаар, нийгмийн танин мэдэхүйн өвөрмөц салбар, нөгөө талаар, сэтгүүл зүйн чиглэсэн зорилготой судалгаа мөн.

Нийгмийн агуулга, үйл явдлын хөгжил хөдөлгөөнд онцгой анхаарч, тэднийг нэгдмэл байдлаар авч үзэх, тусгах, үнэн бодит баримтыг иш үндэс болгох зэрэг хэвлэл мэдээллийн онол, практикийн бүх зүйлийг нийгмийн тухай шинжлэх ухаанаас авсан байдаг. Социологи ба сэтгүүл зүйн ийм харилцан нөлөөлөл нь уншигчидтай агуулга, хэлбэрийн хувьд сонирхолтой, амьд яриа өрнүүлэх баазыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Үйл ажиллагааны ийм хоёр төрлийн зэрэгцэн орших нь нэг нь нөгөөгөө үгүйсгэх-

гүй, харин нэг нь нөгөөгөө улам баяжуулж, сэтгүүл зүй социологиос ертөнцийн тухай, ОНМХ-ийн статус, нийгмийн үүргийн тухай, бодит байдлыг танин мэдэх аргуудын талаар үнэн бодитой мэдлэг олж авахад тусалдаг.

Ер нь сэтгүүлчдийн практикт шинжлэх ухааны мэдлэгийг үл хайхрах тохиолдол цөөнгүй тааралддаг. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйд “экспресс-социологи” гэсэн нэр томъёог хүртэл хэрэглэх болсон. Ажиглалтаас үзэхэд үүнийг судалгааны зорилгоор бус, харин богино хугацаанд үр дүнд хүрэх гэсэн утгаар ойлгох нь нийтлэг юм. Энд арга зүй, баримтууд болон үр дүнгийн найдвартай байдал нь хоёрдугаар байранд тавигдаж, тулгамдсан асуудлыг барьж авах нь хамгийн гол зорилго байдаг. Гэхдээ зөвхөн үнэн бодитой мэдээлэл л түүний шуурхай байдлаас үл шалтгаалан нийгэмд танин мэдэхүйн үнэ цэнтэй байдгийг мартаж болохгүй.

Сэтгүүл зүйн социологийн тэргүүн зэргийн зорилго нь онол дахь, мөн редакцын аппаратын ухамсар дахь нийгмийн болон хүмүүсийн зан үйлийн хэм хэмжээнд үл нийцэх синдромыг даван туулахад оршино.

Сэтгүүлчид амьдрал ертөнцийн тухай мэдлэг яагаад чухал вэ? Зарим хүн, ялангуяа туршлагыг ямар ч мэдлэг, ямар ч онолын дээгүүр тавихыг хичээгчид нийгмийн шинжлэх ухааныг практиктай холбох шаардлагагүй гэж үздэг нь цөөнгүй тааралддаг. Ийм хандлага нийгмийн шинжлэх ухаанд цоо шинэ зүйл биш, түүнийг баримтлах нь хүссэн хүнд нээлттэй гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ өөрийгөө шинэ үеийн сэхээтэн гэж нэрлэдэг тэр хүмүүсийн дунд илүү ихээр газар авах шинжтэй байгаа нь ажиглагддаг. Тэд

гол төлөв өчигдөр редакцын үйл ажиллагааны талаар ямар ч төсөөлөлгүй байгаа мөртөө өнөөдөр хэвлэл мэдээллийн бизнест идэвхтэй оролцож, манай орны болон дэлхий дахины сэтгүүл зүйн хувь заяаны талаар том том юм ярьдаг хүмүүс юм. Ер нь өнөөдөр манай орны сэтгүүлчдийн мэргэжлийн болон хэвлэл мэдээллийн төрийн бус байгууллагуудын дарга нар нь бараг зуун хувь шахуу мэргэжлийн бус хүмүүс байна. Тэд хаана очсон чөлөөт хэвлэлийн эрх зүйн орчин муу байна, шинээр хууль гаргах хэрэгтэй, хуучин хууль эрх зүйн актуудыг шинэчлэх хэрэгтэй, сэтгүүлчдийн нийгмийн асуудал тааруу, материаллаг бааз муу байна гэсэн улиг болсон хэдэн асуудлыг хөнддөг. Харин сэтгүүл зүйн хөгжлийн зүй тогтол, нөлөөлөх хүчин зүйл, шалтгаан үр дагавар, нийтлэл нэвтрүүлгийн чанар, үр нөлөө, сэтгүүлчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга зам, ур чадвар зэрэг тэргүүн зэрэгт хөндөх ёстой асуудлын талаар ам нээдэггүй. Энэ нь сэтгүүл зүй хэмээх бие даасан шинжлэх ухааны талаарх суурь мэдлэг дутмаг байгаатай холбоотой юм.

ОНМХ-ийн удирдлагуудын сэтгүүл зүйн болон ерөнхий суурь мэдлэг дутмаг байгаа нь ихэнх ХМХ нийтлэл, нэвтрүүлгийн тодорхой бодлогогүй, урсгал шинжтэй, улиг болсон хэдэн сэдэв, бичлэгийн төрөл зүйлийн хүрээнд эргэлдэж, мэргэжлийн ямар ч үнэргүй сенсац хөөсөн хэдэн мэдээгээр олон нийтийн тархийг угаахыг урьтал болгох хандлага газар авсан нь бодит зүйл юм.

Харин шинжлэх ухаанаас редакцын үйл ажиллагаанд шаардлагатай “хавсарга материал” эрж хайхыг хичээдэг судлаач, шинжээчдийн бүтээлүүдээс ОНМХ-ийн ажилтнууд сэтгүүл зүйн

хөгжлийн бие даасан нөөцийг олж харахыг хүсэхгүй байгаа нь ажиглагддаг. Америкийн нэгэн шинжээч: “Онолыг практикаас олж авах шилдэг арга бол практикийг чухалчлах явдал юм. Практикт бидний сонирхлыг татдаг туршлага, баримтуудыг олж авдаг, тэгээд туршлагын ач холбогдол, учир утгыг илэрхийлдэг загваруудад ханддаг” (Inglis.F, 1992) гэж тэмдэглэсэн нь үүний тод жишээ юм. Америкийн өөр нэг судлаач өнөөдөр харилцааны хамгийн гол хүчин зүйл бол хүлээн авагчдын нийгэм-хүн ам зүйн болон сэтгэл зүйн шинж чанар, тэдний мэдээллийн хэрэгцээ мөн гэж үзээд, зах зээлийг эзэмшихийн тулд мэдээлэл түгээгчдээс хүлээн авагчид болон медиаг тусгайлан судалдаг хүн ам зүйч, сэтгэл судлаач, эрдэмтэн-судлаач байхыг, эсвэл “наад зах нь болж байгаа үйл явдал, үзэгдлийн жижиг зүйлийг хүртэл таньж мэдэх зөн билгийг хөгжүүлэхийг шаардаж байна” (Brody.E.W., 1990) гэсэн маш үндэслэлтэй дүгнэлт хийжээ. Үүнээс үзэхэд тодорхой учир шалтгааны улмаас туршлага (эмпиризм) редакцын практикийн нөхцөл байдлын талаарх мэдлэгт “буулт хийдэг” нь түгээмэл юм. Энэ баримт өөрөө цаанаа учир утгатай юм. Учир нь сэтгүүл зүйн ба нийгмийн эрх ашгийн талаарх үзэл санаа нэгдэн нийлэх, хэвлэл мэдээлэл нийгмийн орчноос шалтгаалах, үйлдвэрлэлийн үр дүнгийн төлөө нийгмийн өмнө хариуцлага хүлээх хүртэлх цаг хугацаа өнөөдрөөс нэлээд хол байна.

Манай оронд чөлөөт хэвлэлийн эх суурь тавигдсанаар асар богино хугацаанд ХМХ-ийн тоо урьд өмнө байгаагүй хэмжээнд эрс нэмэгдэж, сэтгүүл зүйн хөгжлийн шинэ хандлага эхэлсэн. ОНМХ-ийн систем, нийтлэл нэвтрүүлгийн агуулга, сэтгүүлчдийн

бичлэгийн ур чадвар, бичлэгийн төрөл зүйл, хэвлэл мэдээллийн менежмент, маркетингэд эрс өөрчлөлт гарсан. Бүх юм бидний нүдний өмнө ил байгаа учраас янз бүрийн тоо баримт, жишээ, үнэлэлт дүгнэлтээр тайлбарлах шаардлагагүй. Гэхдээ энэ үйл явц ямар нэгэн тус дэмжлэггүйгээр аяндаа урсгал шинжтэй өрнөсөн. Энэхүү “ОНМХ-ийн хөгжлийн шилжилтийн үе”-д төр засгийн хувьд ОНМХ-ийн зах зээлийг хөгжүүлэх ямар нэгэн стратеги байгаагүй. Энэ бол онолын үүднээс авч үзвэл зарчмын том алдаа байсан. Гэхдээ асуудлын гол нь “шилжилтийн үе”-ийн төгсгөлд ч биш, олон нийтийн мэдээллийн зах зээлийн зохион байгуулалтад ч биш юм. Хамгийн гол нь өнгөрсөн зууны 90-ээд оны эхэнд сэтгүүл зүй онол-арга зүйн үндэс суурийг үндсэндээ бүрэн алдсанд оршино. Социалист нийгмийн үед тийм үндэс суурь байсан. Хэдийгээр бид өнөөдөр шүүмжлэлтэй ханддаг боловч коммунист намын хэвлэлийн онол практик, түүний аргууд ноёрхож байсныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

Ардчилсан шинэ нийгмийн нөхцөлд практик бол онолоос илүү зоригтой, илүү самбаатай, тоо томшгүй өөрчлөлт шинэчлэлтэд түрүүлж ханддаг болсон. Сэтгүүл зүйн шинжлэх ухаанд шилжилтийн үеийн эхний жилүүдэд сэтгүүл зүйн өмнө тулгарсан стратегийн болон тактикийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн алсын хараа, таамаглал дэвшүүлэх дадал чадвар, туршлага, бүтээлч сэтгэлгээ, нөөц боломж хангалттай байгаагүй. Гэхдээ тун удахгүй шалгарсан стратегийн чиг баримжаагүйгээр ХМХ хөгжихөд амаргүй гэдэг нь ажиглагдаж эхэлсэн.

Ардчиллын эхний жилүүдэд ихэнх хэвлэл мэдээллийн хэрэг-сэл хүлээн авагчдаа алдаж, ямар нэгэн хэлбэрийн татаасгүйгээр амьдрах боломжгүй түвшинд хүрсэн. Энэ бол зөвхөн практикийг тахин шүтэж, хувийн авьяас, зөн билэг, түр зуурын ололтод тулгуурлан амжилтад хүрэхгүй гэдгийн нотолгоо байв. Хэдийгээр зарим нэг хувийн ололт амжилт, үйл ажиллагааны цөөн чиглэлд эерэг хандлага ажиглагдсан ч сэтгүүл зүй бүхэлдээ нэлээд удаан үргэлжилсэн хямралд орсон.

Эрүүл ухаанд найдах болон мэргэжлийн “дефолт” хоёрын хооронд зүй тогтлын харилцаа холбоо оршдогийг ОНМХ-ийн өнөөгийн байдалд хийсэн судалгаанаас харж болно. Зөвхөн интернэт сэтгүүл зүйг авч үзвэл агуулгын хувьд ядуу, хэдэн сэдэв, бичлэгийн төрөл зүйлийн хүрээнд эргэлдсэн, ур чадварын хувьд авах юмгүй, мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй, ашиг орлого багатай, эрхлэн гаргагчдын хүсэн хүлээсэн тэр түвшинд хүрч чадахгүй байна. Зөвхөн тооны хувьд мэдээллийн сайтууд нэмэгдэж байгаа боловч чанарын хувьд мэргэжлийн шаардлагаас хол хоцорсон нь ил байна. Үүнийг сэтгүүл зүйн онолд “системийн хямрал” гэж нэрлэдэг. Шалтгаан нь тодорхой. Өөдрөг таамаглал нь ямар ч судалгаанд үндэслэгдээгүй, урсгал шинжтэй, өдөр тутмын хар практикийг тахин шүтсэнтэй шууд холбоотой юм. Хамгийн гол нь “Амжилтын цорын ганц боломж нь тухайн цаг мөч хүртэл хэн ч санал болгоогүй зарчмын хувьд цоо шинэ стратеги” (Монахов.В.Н., 2003) байх ёстой.

Нийгмийн бүхэл бүтэн институт болох сэтгүүл зүйн стратегийн хөтөлбөрийг зөвхөн түүний хамгийн гол шинж чанар, онцлогийг зөв ойлгосон тохиолдолд л боловсруулах боломжтой. Тийм

гүн гүнзгий, системтэй мэдлэгийг үйлдвэрлэлийн өдөр тутмын урсгал ажлаас олж авахгүй. Түүнийг шинжлэх ухаан өгдөг. Онол бол хүний ертөнцийг таньж мэдэх, эзэмших аргуудаас сэтгүүл зүй юугаар ялгаатай вэ, түүнийг бусад шинжлэх ухаантай, тухайлбал, урлаг судлал, шинжлэх ухааны судалгаатай харьцуулж болох вэ гэдгийг олж харах чадвартай. Шведийн социологичдын үзсэнээр “Сэтгүүлчдийн сэтгэхүйн арга барилтай холбоотой тодорхой дэг журмыг харгалзан сэтгүүл зүйг түүхийн бичмэл хэлбэр гэж нэрлэж болно. Тогтмол хэвлэл дэх он дарааллын бичлэг жирийн түүхчидтэй харьцуулахад тийм ч тодорхой бус байдаг. Энэ нь үйлдвэрлэл болон шинэ мэдээ бэлтгэх ажлын тогтмол шинжтэй холбоотой юм” (Ekecrantz J, Olsson. T, 1993)

Судалгааны бүтээлүүдэд “нийтлэл зүй бол орчин үеийн түүх” гэсэн тодорхойлолтыг харгалзан үзэх нь түгээмэл ажиглагддаг. Эндээс логикийн хувьд сэтгүүлчийн хөдөлмөрт зайлшгүй байх тэр хэмжүүрүүдийг олж мэдэх нь чухал. Нийгмийн түүх гэдэг бол хүний баримтат ой санамж гэсэн үг. Тиймээс нүдэнд туссан тархай бутархай баримтуудаас бүрдэх ёсгүй. Өөрөөр хэлбэл бодит байдлыг системтэй, маш нарийн эзэмшихийг шаарддаг.

Энэ бүхэнд юуны өмнө ОНМХ-ийн тухай шинжлэх ухаан, түүний дотор социологийн салбар болох сэтгүүл зүйн социологи хариулт өгөхөд тусалдаг юм. Тэгвэл сэтгүүл зүйн социологи гэж юу вэ?

Сэтгүүл зүйн социологи гэдэг нь нийгэм дэх ОНМХ-ийн ажиллагааны зүй тогтлууд, онцлогийг хүлээн авагчид, хэвлэн нийтлэх, эрхлэн гаргах, удирдах, санхүүжүүлэх бүтцүүдтэй харилцан нөлөөлөлд нь, тэдний бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, түүний нөхцөлийг социологийн аргуудын үндсэн дээр судалдаг социологийн тодорхой нэг салбар мөн.

Судлаачид социологийн энэ салбарын түүхийг Аристотелийн “Улс төр”, “Илтгэх урлаг” зэрэг алдарт бүтээлүүдээс эхтэй гэж үздэг боловч Соён гэгээрлийн үед И.Гутенбергийн хэвлэлийн суурь машин үүсэж, мэдлэг мэдээллийн хэлбэрийг олж эхэлснээр

эх сууриа тавьсан гэж үздэг. 1910 онд Германы социологич Макс Вебер “хэвлэл мэдээллийн социологи” хэмээх ойлголтыг шинжлэх ухааны эргэлтэд оруулж, хэвлэлийг статистик аргаар судлах хөтөлбөрийг боловсруулжээ. XX зууны 30-аад оноос сэтгүүл зүйн социологи эрчимтэй хөгжиж, Франц, Англи, Америк зэрэг оронд сонины уншигчид, радио сонсогчдын санал

«

Нийгмийн бүхэл бүтэн институт болох сэтгүүл зүйн стратегийн хөтөлбөрийг зөвхөн түүний хамгийн гол шинж чанар, онцлогийг зөв ойлгосон тохиолдолд л боловсруулах боломжтой. Тийм гүн гүнзгий, системтэй мэдлэгийг үйлдвэрлэлийн өдөр тутмын урсгал ажлаас олж авахгүй. Түүнийг шинжлэх ухаан өгдөг. Онол бол хүний ертөнцийг таньж мэдэх, эзэмших аргуудаас сэтгүүл зүй юугаар ялгаатай вэ, түүнийг бусад шинжлэх ухаантай, тухайлбал, урлаг судлал, шинжлэх ухааны судалгаатай харьцуулж болох вэ гэдгийг олж харах чадвартай

»

бодлыг судалж эхэлсэн юм. Мөн өнгөрсөн зууны дөчөөд оноос контент-анализын арга өргөн нэвтэрсэн байна. Сэтгүүл зүйн социологийг хөгжүүлэхэд П.Сорокин, Т.Парсонс, У.Липпман, У.Шрамм, Ж.Меррилл (АНУ), Ф.Теннис, Э.Довифат (Герман), Ж.Кэйзер (Франц), Д.Макквейл, Ж.Халлоран (Англи), Е.П.Прохоров, С.Г.Корконо-сенко (ОХУ) нар томоохон хувь нэмэр оруулжээ.

Сэтгүүл зүйн социологийн судлах зүйл нь олон нийтэд зориулагдсан цаг үеийн шуурхай мэдээллийн систем болох ОНМХ-ийн нийгмийн институтүүд болон хүлээн авагчидтай харилцан нөлөөлөлд оршдог нийгэм дэх үйл ажиллагаа юм. Хэрэв ерөнхий социологийн судлагдахууныг өөрчилж, сэтгүүл зүйн социологи руу шилжүүлбэл түүний судлах зүйлийг дараах байдлаар үзүүлж болно. Энэ бол сэтгүүл зүйн дараах үзүүлэлтүүдийг (сэтгүүл зүйн социологийн судлах зүйл) социологийн аргуудаар судална гэсэн үг юм.

ОНМХ-ийн нийгэм дэх үйл ажиллагааны субъектүүд (систем, бүтэц, хэв маяг, бүрэлдэхүүн [нийгэм-хүн ам зүйн шинжүүд, чиг баримжаа г.м.]):

- Эрхлэн гаргах байгууллагууд болон нийгмийн институтүүдийн;
- ОНМХ, сэтгүүлчдийн;
- Хүлээн авагчдын.

Нийгэм дэх ОНМХ-ийн субъектүүдийн үйл ажиллагаа:

- Хэрэгцээ, сонирхол;
- Үүрэг, зорилго, шалтгаан;
- Агуулга ба чиглэлүүд;
- Аргууд, үйлдлүүд;
- Үр дүн, үр нөлөө.

Мэдээллийн үйл ажиллагааны бусад оролцогчдод хандах харилцаа:

- Төр засагтай;

- Нийгмийн бусад институтүүд, намууд, нийгмийн хөдөлгөөн, иргэний нийгмийн байгууллагуудтай;
- Эзэд, эрхлэн гаргагчид, хэвлэн нийтлэгчид, түгээгчид, реклам олгогчид, ивээн тэтгэгчидтэй;
- Хүлээн авагчид ба нийгмийн үзэл санаатай;
- Сэтгүүлчидтэй.

Нийгмийн субъектүүдийн үйл ажиллагааны нөхцөл:

- Өргөн утгаар нь нийгмийн амьдралын нийгэм-улс төрийн, эдийн засгийн, оюуны үйл явцуудын болон нөхцөлийн нийлбэр;
- Явцуу утгаар нь санхүүгийн байдал, материал-техникийн бааз, боловсон хүчний хангамж г.м.

Сэтгүүл зүйн социологийн үндсэн үүргүүд:

- Танин мэдүүлэх
- Тайлбарлах
- Таамаглал дэвшүүлэх
- Практикийг өөрчлөх
- Ертөнцийг үзэх үзлийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх зэрэг юм.

Орчин үед сэтгүүл зүйг маш олон шинжлэх ухаан судлах болсон. Бас тэдний хүрээ жилээс жилд өргөжих хандлага ажиглагдаж байна. Сэтгүүл зүйн социологиос гадна сэтгүүл зүйн түүх, сэтгүүл зүйн сэтгэл зүй, сэтгүүл зүйн эрх зүйн үндэс, сэтгүүл зүйн ёс зүй, сэтгүүл зүйн эдийн засаг, бүтээлч үйл ажиллагааны үндэс гэх мэтээр үргэлжлүүлж болно.

Социологи ба сэтгүүл зүй: нийтлэг болон ялгаатай талууд. Ертөнцийг танин мэдэх, тусгах энэ хэлбэрүүдийн нийтлэг шинж нь юуны өмнө тэд ойролцоо мэдээлэл өгдөгт оршино. Эхлээд нийтлэг шинжүүдийн талаар ярья.

- ✓ Үйл ажиллагааны энэ хоёр төрлийн аль аль нь нийгмийг судлах хүрээнд

багтдаг. Социологи үйл явц болон үзэгдлүүдийн хөгжлийг таамаглахыг гол болгодог бол сэтгүүл зүй өдөр тутмын практикт гол анхаарлаа хандуулдаг.

- ✓ Тэдний баримтлах зарчмын чиг баримжаа нь ижил төстэй. Өөрөөр хэлбэл, нийгмийн хариуцлагатай, энэрэнгүй үзлийг эрхэмлэх, иргэний ашиг сонирхлыг хүндэтгэх, найдвартай болон үнэн бодитой мэдээлэл олж авахыг хичээхийг чухалчилдаг.
- ✓ Тэдний судлах, тусгах объектууд нь ч ижил төстэй. Объектив (баримтууд, зан үйл) болон субъектив (үзэл бодол, сонирхол, харилцаа) хэмжүүрээр авагдсан орчин үеийн нийгэм, түүний бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүд байдаг. Гэхдээ социологи нийтийг хамарсан статистик тоо баримт болон үйл явцыг голлон анхаардаг, хэвлэл мэдээлэл бол гол анхаарлаа сонирхол татахуйц үйл явдлууд, хувь хүн руу хандуулдаг.
- ✓ Хөдөлмөрийн бараг адилхан цогц аргуудыг хэрэглэдэг. Тэдний дотор социологи нийтийг хамарсан статистикийн болон хэлбэржсэн (формаль) аргуудыг голлон хэрэглэдэг бол сэтгүүл зүй тодорхой үйл явдал, хүмүүстэй нэлээд гүнзгий танилцахыг чухалчилдаг.
- ✓ Социологичийн хувьд ханддаг гол субъект нь (бүтээгдэхүүнийг хэрэглэгч нь) удирдах байгууллагууд, мэргэжилтнүүд бол сэтгүүлчдийн хувьд нийт хүлээн авагчид байдаг. Гэхдээ социологичдод эрдэмтдийн нэгэн адил олон нийттэй харилцах шаардлага гардаг бол хэвлэл мэдээллийн ажилтнууд зөвхөн шаардлагатай тохиолдолд л удирдах байгууллагуудад ханддаг.
- ✓ Социологи ба сэтгүүл зүй нэг нэгийгээ мэдээллээр харилцан хангах замаар статистикийн чухал

баримтууд ба зүй тогтлууд нийгмийн амьдралын янз бүрийн илрэлүүдийн тусгалтай холбогдон нэгдмэл, бүрэн төгс дүр зургийг бүтээдэг.

Дээр дурдсан шинжүүд юуны өмнө мэдээллийг цуглуулах, боловсруулах, түгээх буюу туршилтын үйл ажиллагаатай холбоотой. Хэрэв бид онолын болон ОНМХ-ийн ажилтнуудын мэргэжлийн ухамсрын тухай ярих юм бол бидний сонирхлыг нийгмийн тухай шинжлэх ухааны нэг болох сэтгүүл зүйн тухай төсөөллөөс урган гардаг системийн шинжилгээний үзэл баримтлал, хандлага, арга зүй татах болно. Хэвлэл мэдээллийн зорилгыг ч, үүргийг ч, бусад институтүүдийн хоорондох харилцаа холбоог ч, нийгмийн амьдралд үзүүлэх нөлөөллийн хэмжээг ч социологийн ухааны тогтмол судалж, дүгнэн тайлбарладаг нийгэмд бодитой төлөвшин тогтсон хүчнүүдийн үүргүүдийн хуваарилалт, тэдний үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэхгүйгээр ойлгох боломжгүй юм. Тийм төрлийн материалууд аажим аажмаар хуримтлагддаг бөгөөд түүнийг социологийн тусгай онол болох олон нийтийн харилцааны хэрэгслийн социологийн онолоор тайлбарладаг. Түүний гол зорилго нь “нэг талаар, олон нийтийн харилцааны үйл явцуудын нийгэмтэй холбогдсон байдал, нөгөө талаар, тэдний үйл ажиллагааны нийгмийн үр дагавар, өөрөөр хэлбэл нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын үзэгдэлд үзүүлэх нөлөөг судлахад” (Д.М.Гвишиани, Н.И.Лапина, 1998) оршино.

Сэтгүүл зүйн социологийн онолын үндэс бүрэн төгс томъёологдсон гэж үзэх боломжгүй. Учир нь:

Нэгдүгээрт, аливаа үзэгдэлд зөвхөн гадна талаас нь хандах замаар

түүнийг бүрэн мэдэх боломжгүй. Учир нь хөндлөнгийн ажиглагчийн олж, хүрч чадахгүй дотоод зүй тогтол, нууц зүйл ямагт оршиж байдаг.

Хоёрдугаарт, сэтгүүл зүй бол зөвхөн харилцааны шалгууруудаар хэмжиж болохгүй олон жилийн туршлагын үр дүнд бий болсон өөрийн гэсэн үзэл баримтлалтай олон талт, иж бүрэн нэгдмэл зүйл юм. Сэтгүүл зүйг харилцааны үүднээс тайлбарлахын тулд янз бүрийн үндэслэл, шалтгааныг эх сурвалж болгон, түүний дотор гадаадын нийгмийн шинжлэх ухааны хөгжлийн үндсэн чиг хандлага нь тийм байсан гэсэн тайлбар хэлдэг тохиолдол цөөнгүй ажиглагддаг. Сэтгүүл зүй харилцаа гэдэгтэй хэн ч маргахгүй, энэ чиглэлийг улам эрчимтэй судлах, хөгжүүлэх шаардлагатай. Харин түүний оюуны, улс төрийн, гоо зүйн болон бусад үнэт зүйлсийг бүтээхэд бүтээлч үйл ажиллагааг, нийгмийн өөрийгөө удирдах институт болох, үйлдвэрлэлийн тодорхой нэг салбар болох ач холбогдлыг үгүйсгэх, дутуу үнэлэх боломжгүй юм.

Гуравдугаарт, сэтгүүл зүйн социологи бол ОНМХ-ийн систем доторх бүх хөдөлгөгч хүчнүүд, зүй тогтлууд, үйл явцуудыг гүнзгийрүүлэн судалдаг шинжлэх ухааны танин мэдэхүйн өргөн дэлгэрсэн бие даасан салбар болох сэтгүүл зүйн онолын тодорхой нөлөөн дор төлөвшсөн байдаг. Сэтгүүл зүйн социологи энэ онолын голдиролд хөгждөг, гэхдээ түүнд уусаж алга болохгүй, харин судлах зүйл, зорилго, аргын хувьд онцгой байр эзэлдэг.

Дүгнэлт. Сэтгүүл зүйн социологи бол ОНМХ-үүдийн төлөв байдал, хөгжлийн үйл явц, үйл ажиллагааных нь нийгмийн үр дагаврыг нийгмийн хүчин зүйлсийн нөлөөлөлд нь авч судлах

социологийн салбар ухаан бөгөөд гол зорилго нь нийгмийн бүтэц эсвэл олон нийтийн санаа бодолд гарсан ямар өөрчлөлт сэтгүүлчийн сэтгэхүй болон зан үйлийн хэлбэр, төсөөлөл, чиглэл, зорилгод яаж нөлөөлөх вэ гэдгийг ойлгуулах, тайлбарлахад оршино. ОНМХ-ийн системийн доторх хөдөлгөгч хүчнүүд, үйл явц, зүй тогтлуудыг гүнзгийрүүлэн судалдаг шинжлэх ухааны танин мэдэхүйн бие даасан, өргөн хүрээтэй салбар болох сэтгүүл зүйн онолын нөлөөн дор бүрэлдэн тогтдог бөгөөд шүүмжлэх, чиг баримжаа тогтоох, таамаглал дэвшүүлэх үүргийг голлон гүйцэтгэдэг. Сэтгүүл зүйн социологийн судлах зүйл нь олон нийтэд зориулагдсан цаг үеийн шуурхай мэдээллийн систем болох ОНМХ-ийн нийгмийн институтууд болон хүлээн авагчидтай харилцан нөлөөлөлд оршдог нийгэм дэх үйл ажиллагаа юм.

Социологи ба сэтгүүл зүйн харилцан нөлөөлөл нь уншигчидтай агуулга, хэлбэрийн хувьд сонирхолтой, амьд яриа өрнүүлэх баазыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Үйл ажиллагааны ийм хоёр төрлийн зэрэгцэн орших нь нэг нь нөгөөгөө үгүйсгэхгүй, харин нэг нь нөгөөгөө улам баяжуулж, сэтгүүл зүй социологиос ертөнцийн тухай, ОНМХ-ийн статус, нийгмийн үүргийн тухай, бодит байдлыг танин мэдэх аргуудын талаар үнэн бодитой мэдлэг олж авахад тусалдаг.

Социологи ба сэтгүүл зүйн аль аль нь нийгмийг судлах хүрээнд багтдаг, баримтлах зарчмын чиг баримжаа нь, судлах, тусгах объектууд нь ч ижил төстэй, хөдөлмөрийн бараг адилхан цогц аргуудыг хэрэглэдэг, нэг нэгийгээ мэдээллээр харилцан хангах замаар статистикийн чухал баримтууд ба зүй тогтлууд нийгмийн амьдралын янз бүрийн илрэлүүдийн тусгалтай

холбогдон нэгдмэл, бүрэн төгс дүр зургийг бүтээдэг.

Сэтгүүл зүйн социологи бол сэтгүүл зүйн онолын тодорхой нөлөөн дор төлөвшиж, энэ онолын голдиролд хөгждөг боловч түүнд уусаж алга болохгүй, харин судлах зүйл, зорилго, аргын хувьд онцгой байр эзэлдэг.

Эшлэл

1. Inglis, F. 1992. Media Theory. An Introduction. Oxford (UK); Cambridge (USA), p. 193.
2. Brody, E.W. 1990. Communication Tomorrow: New Audiences, New Technologies, New Media. New York (USA), p 67.
3. СМИ и Интернет: проблемы правового регулирования (Авт.-сост. В. Н. Монахов). М., 2003. с. 24.
4. Ekecrantz, J., Olsson, T. 1993. Journalism: Discursive Order and Social Practice. A Research Programme on News Media and Social Change in 20th Century Sweden. Stockholm, p. 10, 11.
5. Краткий словарь по социологии (Под общ. ред. Д.М. Гвишиани, Н.И. Лапина). М., 1988. с. 347, 348.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль, М. Сэтгүүл зүйн социологи: онол, практик, арга зүй. УБ., 2020.
2. Зулькафиль, М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 2018.

3. Краткий словарь по социологии (Под общ. ред. Д.М. Гвишиани, Н.И. Лапина). М., 1988.
4. Прохоров Е.П. Журналистика и демократия. М., 2004.
5. СМИ и Интернет: проблемы правового регулирования (Авт.-сост. В. Н. Монахов). М., 2003.
6. Brody, E.W. 1990. Communication Tomorrow: New Audiences, New Technologies, New Media. New York (USA).
7. Ekecrantz, J., Olsson, T. 1993. Journalism: Discursive Order and Social Practice. A Research Programme on News Media and Social Change in 20th Century Sweden. Stockholm.
8. Inglis, F. 1992. Media Theory. An Introduction. Oxford (UK); Cambridge (USA).

Summary

This article discusses the relationship between journalism and sociology, commonalities and differences, and the importance and impact of journalism in mass media studies. Also, in reflecting on the above problems, the author conducts an evaluation, systems analysis, and structural examination of the practical activities of Mongolian mass media and offers an overall appraisal and conclusion. The article is significant as it marks the beginning of an in-depth study of the sociology of journalism.